

Д.Моломжамц: Хөтөлбөрүүд үр дүнгээ өгч эхэлж байна.



Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч асан, гавьяат эдийн засагч, эдийн засгийн шинжлэх ухааны доктор Д.Моломжамц гуайтай уулзаж, эдийн засгийн тогтворжуулах арга хэмжээ, түүний хүүрээнд хэрэгжүүлж буй үнэ тогтворжуулах хөтөлбөрийн талаар ярилцлаа.

Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах зорилгоор Засгийн газар, Монголбанкт хамтран дэд хөтөлбөрүүдийг дунд хугацаанд хэрэгжүүлэхээр эхлүүлсэн. Хөтөлбөрийн жилийн үр дүнг та хэрхэн дүгнэж байна вэ?

Хөтөлбөрүүд үр дүнгээ өгч эхэлж байна гэж бодож байна. Энэ жилийн хувьд анх удаа ийм хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн, бид энэ талаар туршлага багатай байсан хийгээд тэдгээрийг хэрэгжүүлэх орчин нөхцөл сайнгүй байсан хэдий ч гол нэрийн бараа, үйлчилгээний үнэ, тарифын өсөлтийг хязгаарлах, яваандаа бууруулах, хяналтад авах нөхцлийг бүрдүүлж өглөө. Мөн эдгээр хөтөлбөрүүдийн ачаар эдийн засгийн өсөлтийг дэмжиж чадлаа шүү дээ. Иймээс эдгээр хөтөлбөр нь зөвхөн гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах төдийгүй, макро түвшинд эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн хөтөлбөр гэж хэлмээр байна. Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүд сайнтай муутай янз бүр л байна.

Гэхдээ гол үзүүлэлтүүд муугүй гарч байна шүү дээ. Манай улсын эдийн засгийн бодит өсөлт гурав дахь жилдээ дараалан хоёр оронтой тоотой гарч байна. Гадаад эдийн засгийн орчин өөрөө их муудсан, хоёр хөршийн эдийн засгийн байдал сайнгүй байгаа болон манай экспортын орлого огцом багассан, хөрөнгө оруулалт эрс татарч, макро эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн хэдий ч ДНБ-ийг 11.5 хувиар өсгөнө гэдэг сайн үзүүлэлт. Өнгөрсөн оны эцэст 14 хувьтай гарсан инфляци энэ оны 11 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 12 хувь, Улаанбаатар хотод 11.1 хувь болж буурсан байна. Мах, гурил, шатахууны үнэ харьцангуй тогтвортой, эдгээр бүтээгдэхүүний үнийн өсөлтийн хурд нь өмнөх онуудтай харьцуулахад 2 гаруй дахин бага байгаа нь иргэдийнхээ бодит орлогыг хамгаалахад чухал нөлөөлөл үзүүлсэн. Гэхдээ бүх юм болж бүтэж, сайн сайхан болж байна гэж хэлж болохгүй л дээ. Бидэнд шийдэх, хэрэгжүүлэх ёстой, хүндрэлтэй олон асуудал байна, энэ талаар дээр доргүй мэдэж, ажиллаж байгаа нь ойлгомжтой.

2014 онд ч үнэ тогтворжуулах хөтөлбөр үргэлжилнэ. Энэ тал дээр та ямар байр суурьтай байна вэ? Хөтөлбөртэй холбоотой эрсдэл бий юу?

Үнэ тогтворжуулах хөтөлбөр бол дунд хугацааны хөтөлбөр. Эдгээр хөтөлбөрийг ирэх онд төдийгүй ойрын 3 жилийн турш тасралтгүй хэрэгжүүлж байж үр дүнд хүрнэ. Энэ хөтөлбөрүүдийн эцсийн зорилго нь зах зээлд, хувийн секторт суурь бараа бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, эрэлт, нийлүүлэлтийн зохистой харьцааг бий болгоход чиглэж байгаа шүүдээ. Тийм ч учраас ирэх оны мөнгөний бодлогыг баталсан УИХ-ын тогтоолд хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, арга хэрэгслүүдийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэр рүү шат дараатай шилжүүлэх, хөтөлбөрүүдийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллахыг Засгийн газарт даалгасан байна билээ. Энэ бол яалт ч үгүй Засгийн хийх ажил л даа. Эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга механизмыг боловсронгуй болгох, хяналтыг сайжруулах хэрэгтэй санагдана. Зээл өгсөн банк зээлдэгчдээ, Засгийн газар гэрээ байгуулсан аж ахуйн

нэгжүүддээ, Монголбанк банкууддаа гэх мэтээр. Яваандаа хэдэн жилийн дараа Монголбанк энэ хөтөлбөрөөс гараад явчихлаар банкууд, аж ахуй нэгжүүд л Засгийн газар, Монголбанкны хамтран бий болгосон тогтолцоог нь цэвэр бизнесийн хүрээндээ үргэлжлүүлээд аваад явах юм.

Ямар арга замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах вэ, бас хяналтын талаар?

Манайд гол нэрийн бараа, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт харьцаа алдагдсан тэгээд бас эдийн засаг маань банкны богино хугацаатай зээл дээр суурилсан, өр нь хэврэг бүтэцтэй эдийн засагтай шүү дээ. Манай эдийн засаг эрсдэл даах чадвар багатай, гадаад орчин муудахад шууд нөлөөлдөг. Хавар мах ховордохоор үнэ нь талийдаг, үр тарианы нөөцгүйгээс гурилын үнэ өсдөг, Оросууд шатахууны экспортын үнийг нэмэх, эсвэл валютын ханш өсөх үед дотоодод шатахууны үнэ нэг өдрийн дотор л огцом 200-300 төгрөгөөр нэмэгддэг, Замын-Үүд боомт дээр ачаа бараа тээвэрлэгдэхгүй гацсанаас болж импортоор орж ирдэг өргөн хэрэглээний барааны үнэ огцом өсдөг. Иймээс нэг хэсэгтээ төрийн оролцоо, зохицуулалт байхаас аргагүй. Иймээс эрэлт, нийлүүлэлтийн зохистой харьцаа алдагдсан салбар, дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн ажиллагаагаг хангах замаар ард түмний аж амьдралын түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд эдгээр болон бусад зарим тодорхой хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх нь чухал санагдана. Харамсалтай нь энэ оны хувьд төсвийн бодлогоор дамжуулж мөнгөний бодлогыг сайн дэмжиж чадсангүй. Энэ оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө бараг 60 гаруй хувиар тасалдсан байна. Үүний улмаас бий болж байгаа олон сөрөг үр дагавар хэнд ч ойлгомжтой шүү дээ.

Зарим хүмүүс энэ арга хэмжээг хэрэгжүүлэх болсон хуулийн үндэслэлийн талаар асуудаг. Хөтөлбөр хуулийн дагуу хэрэгжсэн үү?

Тиймээ, хуулийн дагуу л арга хэмжээ. Хууль зөрчиж бодлого хэрэгжүүлнэ гэж юу байхав дээ. Би андуураагүй бол саяхан УИХ-аас Монголбанкинд хийсэн шалгалтын үр дүнг тайлагнахдаа хөтөлбөр хуулийн хүрээнд хэрэгжиж байна гэж дүгнэсэн байсан санагдана.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээс бизнесийн салбарт тэгш бус байдал үүссэн үү? Үнэ тогтворжуулах хөтөлбөрт хамрагдах эрх бүх компаниудын өмнө нээлттэй юу?

Инфляцийг өдөөдөг яг тодорхой нэр төрлийн мах, гурил, шатахуун зэрэг бүтээгдэхүүн дээр энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Монголбанкнаас арилжааны банкинд дээр нээсэн зээлийн шугамыг ашиглан тухайн арилжааны банк Засгийн газартай гэрээ байгуулсан харилцагчийн эрсдэлийг өөрөө үнэлж, мах, гурил, үр тариа, шатахууны биет нөөцийг санхүүжүүлж, тэгснээрээ эдгээр барааны үнэ харьцангуй тогтвортой байж, инфляци буурах ёстой. Монголбанкнаас гаргасан зээлийн эх үүсвэр нь мах, гурил, үр тариа, шатахууны биет нөөц болоод буцаад эдгээр бүтээгдэхүүн борлогдохын хэрээр гаргасан зээл эргэж төлөгдөж байна гэсэн үг. Уг хөтөлбөрт хамрагдаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч компаниар оролцох боломж нь бүх аж ахуй нэгжид нээлттэй байгаа. Гагцхүү тухайн компани нь Засгийн газраас тавьж байгаа шалгуурт тэнцэхийн зэрэгцээ арилжааны банкуудаас тавих шалгуур нөхцлүүдийг хангаж байх ёстой. Тэгэхээр энэ бол макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгыг хангахын тулд цэвэр бизнесийн өрсөлдөөний зарчмаар, хувийн хэвшлээр дамжуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээ юм. Олон улсад ч ийм туршлага байдаг. Жишээ нь Өмнөт африкийн Ботсван улсад гэхэд нефть бүтээгдэхүүнээ гаднаас авдгаас түүний үнийн өөрчлөлт шууд инфляцид нөлөөлдөг тул шатах тослох материалын үнийг тогтвортой байлгах сан байгуулж, үр дүнд хүрч

байгаа сайн туршлага бий. Мөн цагаан будаа, улаан буудай, эрдэнэ шиш гээд хөдөө аж ахуйн голлох бүтээгдэхүүний агуулах дахь биет нөөцийг санхүүжүүлэх тогтолцоог хувийн секторт бий болгох замаар эдгээр бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтвортой байлгасан, нийлүүлэлтийн үр ашигтай системийг бүрдүүлсэн сайн туршлага Азийн орнуудад олон байдаг л даа. Тэгэхээр хөтөлбөрөөс болж бизнесийн салбарт тэгш бус байдал үүссэн гэх үндэсгүй. Харин цаашид хэрэгжүүлэх хөтөлбөрийн төслийг боловсруулалт, хэрэгжүүлэх арга замыг улам сайжируулах, зарим төсөлд Үндэсний аудитын газраар экспертиз, дүгнэлт хийлгэн олон талаас нь судалж, бас олон түмэнд улам илт тод байдлаар ойлгуулан, тэдний санал, дэмжлэгийг авах замаар хэрэгжүүлсэн төслууд улам үр дүнтэй байх болов уу.

Ам.долларын ханиш өсч байгаатай холбоотойгоор дэд хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл валютын ханшны өөрчлөлтөөс үүдэн эргэн төлөлт тааруу байна гэж байнгын хороон дээр ярьсан. Үнэхээр ийм эрсдэл байгаа юу?

Зээл авсан аж ахуй нэгжүүд зээлээ гадаад валютаар биш төгрөгөөр авсан. Ийм учраас тэдэнд валютын ханшийн эрсдэл үүсэх ёсгүй. Төгрөгөөр авсан зээлээ төгрөгөөр л эргүүлж төлөх учиртай. Олгосон зээлээ эргэж төлүүлэх үүргийг банкууд хүлээсэн учраас тэд найдвартай, зээлээ төлж чадах компанид л зээл олгосон байж таарна. Энэ бол ямар нэг татаас буюу дэмжлэг биш, зах зээлийн зарчмаараа явж байгаа зээлийн харилцаа байгаа шүүдээ.

Ярилцсанд баярлалаа

Н.Марал